

**БОДЛОГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Б.НИНЖИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			1	2	3	4	5	6
НЭГ. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГСНО.								

1.	Арга хэмжээ 1.1. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна. 1.1.1. Хэрэгцээ шаардлагын урьдчилсан үнэлгээ хийнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	20%	<p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/56 дугаар тушаалаар “Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө”-г баталсан. Тус төлөвлөгөөний 3.6 заалтыг хэрэгжүүлэх зорилгоор олон улсын ижил төстэй байгууллагын үйл ажиллагааны туршлагаас судалсан.</p> <p>Солонгос Улсын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлагийн Нийгмийн эрүүл мэндийн шуурхай удирдлагын газар, Биобанк, нэгдсэн лабораторитай танилцсан. Тус байгууллага нь 8 газартай, 32 хэлтэстэй, харьяа 34 эрүүл мэндийн байгууллагатай, орон нутагт төвүүдтэй. 2020 оны 9 дүгээр сард бие даасан төрийн захиргааны агентлаг болж өөрчлөн зохион байгууллагдсан. Орон нутагт 5 бүсийн төвтэй. Орон нутгийн засаг захиргааны байгууллагтай хамтарч ажиллаж байгааг</p>	1-3 сар	100%
----	--	---	---	-----	--	---------	------


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
					өөрийн орны эрүүл мэндийн тогтолцоотой харьцуулан судалсан ДЭМБ-ын Нийгмийн эрүүл мэндийн талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн 12 чиглэлийг 2024 оны 01 дүгээр сард зөвлөмж гаргасан. Мөн ДЭМБ-ын 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 77 чуулганаас Олон Улсын Эрүүл мэндийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан. Дээрх олон улсын хандлага болон өөрийн орны хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, төв байгуулах танилцууллыг бэлтгэсэн.		
2.	1.1.2. Ажлын хэсгийг байгуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/37 дугаар тушаал батлуулсан. Тус ажлын хэсэг 2024 оны 02 дугаар сарын 29, 03 дугаар сарын 13, 05 дугаар сарын 5-ны өдөр 3 удаа хуралдсан. ХӨСҮТ, НЭМҮТ, ЗӨСҮТ-ийн Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/401, 2023 оны А/71, 2023 оны А/305 дугаар тушаал дээр дүрэм, бүтцийн чиг үүргийн шинжилгээг хийсэн. Мөн ХӨСҮТ, НЭМҮТ, ЗӨСҮТ-ийн удирдлага, тандалтын нэгжийн дарга нар Өвчний хяналт, сэргийлэлтийн төвийн дүрэм, бүтэц, бусад орны туршлагын талаар байгууллага дотроо хэлэлцэж, саналаа ирүүлснийг ӨХСТ-ийн дүрэм, бүтцийн төсөлд тусгаад байна. 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Дүүргийн эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн удирдах албан	3 сар	100%

20


g

g


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
					тушаалтан, эмч, мэргэжилтэн 67 албан хаагчийг оролцуулан ӨХСТ, НЭМТ-ийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.		
3.	1.1.3. ӨХСТ байгуулах төсөл боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	20%	Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тухай хууль 11.2, Засгийн газрын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3.5, ажлын хэсгийн хэсгийн гишүүд, ХӨСҮТ, НЭМҮТ, ЗӨСҮТ, 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн уулзалт хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган, ӨХСТ-ийн зардлын тооцоо хийж, Засгийн газрын тогтоолын төсөл, дүрмийн теслийг боловсруулж, ЭМЯ-ын УЗ-ийн хурлаар 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. УЗ-ийн шийдвэр Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах тесвийн тооцоог нарийвчлан гаргахыг Санхүү, эдийн засгийн газарт, дүрмийн теселд Удирдлагын зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган 6 сарын 18-ны өдөр УЗ-ын хурлаар дахин хэлэлцүүлэхийг бодлого төлөвлөлтийн газарт тус тус үүрэг болгосон.	4-6 сар	70%
4.	1.1.4. Төсөлд яамдуудаас санал авна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	ЭМЯ-ны УЗ зөвлөлийн шийдвэрийн дагуу Үндэсний хэмжээнд байгуулагдах ӨХСТ-ийн эдийн засгийн тооцоолол, шаардагдах тесвийг гаргуулахаар АХБ-ын МОН-6652: халдварт бус өвчний хяналт эмийн аюулгүй байдлыг сайжруулах нь техник туслалцааны төслөөс техникийн дэмжлэг авсан. Төслийн зөвлөх багаас НЭМҮТ,	6-8 сар	0%




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
1	2	3	4	5	6	7		
					ЗӨСҮТ, ХӨСҮТ өөрчлөн зохион байгуулах замаар ӨХСТ байгуулахад 20 тэрбум шаардлагатай зардлын тооцоо гарсан. 2024 оны 8 дугаар сарын төсвийн тодотголд ӨХСТ, аймаг, дүүргийн НЭМТ байгуулахад шаардлагтай санхүүжилтийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсвийн тодотголоос хасагдсан.			
5.	1.1.5. Яамдын саналыг тусган боловсруулсан төслийг ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	40%	ӨХСТ-ийн дүрэм, бүтцийн төсөл дээр хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу олон нийтээс санал авахаар ЭМЯ-ны веб сайтад 30 хоног байршуулсан бөгөөд ХӨСҮТ-ийн шуурхай удирдлагын нэгж, Сурьеэ судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөс ирүүлсэн саналыг ЗГ-ын тогтоолын төсөлд тусгасан. 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 06 дугаар тогтоолоор ЭМЯ-ны бүтцийг шинэчлэн баталсан. Тус бүтцийн дагуу Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт ӨХСТ, аймаг, дүүргийн НЭМТ байгуулах чиг үүрэг хамаарах болсон. Үнэлэх боломжгүй.	8-12 сар	D	
6.	Арга хэмжээ 1.2. Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулна.	Сайдын тушаал батлуулсан эсэх /Тийм:1, Үгүй:0/	1	-	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтцийг шинэчлэн гаргахаар хүний, нөөц орон тооны шинжилгээг хийсэн. Дүрэм, бүтцийг боловсруулж байна.	1-12 сар	30%	
7.	Арга хэмжээ 1.3. 10 аймаг, 3 дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна.	Байгуулсан Нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо	10 аймаг	10 аймаг, 3 дүүрэг	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/56 дугаар тушаалаар “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө”-г баталсан. Тус төлөвлөгөөний 3.6-д аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төвийн дүрэм, бүтцийг батлуулахаар тусгасан.	1-12 сар	50%	




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
8.	Арга хэмжээ 1.4. Нийслэлийн харьяа 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал, зөвлөмжийг хүргүүлнэ.	Нөхцөл байдлын дүн шинжилгээ /Тийм:1, Үгүй:0/	-	1	<p>Тус төвийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг хийж үнэлгээний дүн болон ӨХСТ-ийн ерөнхий бүтцийн төсөлтэй уялдуулан НЭМТ-ийн бүтцийн шинэчлэх төслийг боловсруулсан. Төслийг ӨХСТ байгуулахтай холбогдуулан зохион байгуулсан хэлэлцүүгийн үеэр буюу 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр (Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага, Аймаг, нийслэлийн ЭМГ, Дүүргийн эрүүл мэндийн төв, НЭМТ-ийн удирдах албан тушаалтан, эмч, мэргэжилтэн 67 албан хаагч оролцсон) НЭМТ-ийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөлөөс 6/2121 тоот албан бичгийг хүргүүлэн саналыг авсан. Дээрх саналыг тусган төслийг боловсронгуй болгож байна.</p>		




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
					мэндийн газрын даргын 2014 оны А/97 дугаар тушаалаар харьяа эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн зохион байгуулсан ба Дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн жишиг загварыг баталсан. Тус тушаал хүчингүй болоогүй бөгөөд зөвхөн 2 байгууллага тус жишиг загварыг үндэслэн бүтцийн тушаалыг баталсан байна.		
	Бодлогын хувилбар, санал гарсан байна. /Тийм:1, Үгүй:0/	-	1	Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөлд 9 дүүргийн Эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт нийцээгүй. Түүнчлэн эмнэлгийн тусlamж, үйлчилгээг өргөжүүлэн 1520 оронд хэвтүүлэн эмчлэх тусlamж үзүүлж байна. Дээрх дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан. УЗ-ийн шийдвэр: Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтцийн загварыг Эрүүл мэндийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах.	4-6 сар	50%	
	Санал, зөвлөмжийг НЭМГ-т хүргүүлсэн эсэх /Тийм:1, Үгүй:0/	-	-	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга) 2024 оны 06 сарын 05 ны УИХ-аар соёрхон батлагдсан. Хуулийн 4.4 дүгээр зүйлд 100000-с доошгүй хүн амтай, дэд бүтэц хөгжсөн, улсын эдийн засаг нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой хотыг Улсын зэрэглэлтэй байхаар заасан. Нийслэлийн төвийн 6 дүүргийн хүн ам тус бүр 100000-с дээш тул хуулиар улсын зэрэглэлтэй хот болох эрх зүйн орчин бурдсэн байна. Тус хуулийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний	8-9 сар		



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
					өдрөөс дагаж мөрдөнө. Хуулийн хэрэгжилтэй уялдуулан дүүргийн ЭМТ, нэгдсэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох боломжтой юм. Үнэлэх боломжгүй.		
9.	Арга хэмжээ 1.5. Арга хэмжээ 1.5. НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 94-100, 132 дэх заалтуудыг хэрэгжүүлж, тайланг хугацаанд нь хүргүүлнэ.	Боловсруулсан төлөвлөгөө <i>1. Тайлбар 2. Хуралдааны ажиллагааны үзүүлэлт 3.</i>	2023 он	Үйл ажиллагааны тайлан	Зөвлөмж 116.30: Хүмүүсийг бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, интерсекс байдал, хүйсийн илэрхийлэл зэрээр ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэхээс хамгаалах хуулийн заалтыг улам боловсронгуй болгох, хэрэгжүүлэх; Эрүүл мэндийн сайдын тушаалаар Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохицуулалтыг тусгах чиглэлээр судлан ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд төсөлд Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд баримтлах зарчимд 4.1.6-д ялгаварлан гадуурхалтаас ангид, хүний эрхийг дээдлэх, 4.1.10-д жендерийн эрх тэгш байдлыг хангах заалтуудыг тусгасан. Зөвлөмж 116.35: Хүний эрх, ялгаварлан гадуурхах, түүний дотор бэлгийн чиг	1-12 сар	100%




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			1	2	3	4	5	
					<p>хандлага, хүйсийн баримжаагаар нь ялгаварлахтай тэмцэх сэдвээр эрүүл мэндийн ажилтнууд, шүүгч, цагдаагийн алба хаагчид, хорих байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах;</p> <p>Хүний эрх, ялгаварлан гадуурхах, түүний дотор бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаагаар нь ялгаварлахтай тэмцэх сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулахаар хөтөлбөрийг батлуулаад байна.</p> <p>Зөвлөмж 116.29: <i>ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хүлээцтэй байдлыг хөхиүүлэн дэмжих зорилгоор олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг эхлүүлэх;</i> <i>ЭМЯ-ны мэргэжилтнүүдэд “Ялгаварлан гадуурхалтаас ангид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээ” сургалтыг Залуус Эрүүл Мэнд Төв ТББ-тай хамтран зохион байгуулсан.</i></p> <p>Зөвлөмж 116.34: <i>Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, хууль сахиулах байгууллагуудад үр дүнтэй сургалт зохион байгуулах замаар ЛГБТИ хүмүүсийн талаарх хэвшмэл, өрөөсгөл ойлголттой тэмцэх;</i></p>			




Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			1	2	3	4	5	
					"Зүүн өмнөд Азийн орнуудын эрсдэлт бүлгийн /ЛГБТИ/ хүн амд үзүүлж буй ХДХВ-ийн тусlamж, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах хөтөлбөр -2" төслийн 2023 оны хэрэгжилтийн тайлан, дүгнэлтийн уулзалтад ЭМЯ-ын Нийтийн эрүүл мэндийн газар, Бодлого, төлөвлөлтийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ХӨСҮТ, ТББ, иргэд оролцож эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.			

Нэмэлт үүрэг даалгавар (Арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Эмч нарын VII их хурал зохион байгуулах	5 жил тутамд зохион байгуулах, Оноор	2019	2024	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн "Эмч нарын их хурал зохион байгуулах тухай" 261 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Монголын Эмч нарын VII их хурал" -ыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Их хуралд УИХ, Засгийн газар,	2024.09.23 2024.10.17	100%




					Эрүүл мэндийн яам, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төрөлжсөн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, дүүрэг, өрхийн эрүүл мэндийн төв зэрэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын төрөлжсөн байгууллагын төлөөлөл зэрэг 850 гаруй төлөөлөгч оролцож, цахимаар нийт 1442 санал, хурлын "Хэлэлцүүлэг-1"-ийн явцад 23 асуулт, "Хэлэлцүүлэг-2"-ын явцад 7 асуулт, санал тус тус гарсан. гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох газар, хэлтсүүд 2025 оны жилийн төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтийг ханганд ажиллах шийдвэр гарсан.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Уушгины хорт хавдрын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо эмчилгээний талаарх бодлогын санал зөвлөмж гарган, хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрт тусгах	Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрт тусгах уушгины хавдрын эрт илрүүлгийн алгоритм, оношилгоо, эмчилгээний заавар боловсруулах	?	Уушгины хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо эмчилгээний зааврыг боловсруулж, Хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрт тусгасан байна.	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/331 дүгээр тушаалаар "Хавдраас сэргийлэх, хянах" хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/350 дугаар тушаалаар "Зонхилох байрлалын хавдрын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх бодлогын санал гаргах, хөтөлбөр боловсруулах" дэд ажлын хэсэг, 2024 оны А/351 дугаар тушаалаар "Ходоод, улаан	2024.08.15 2024.12.03	100%



хоолой, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдар”, 2024 оны А/352 дугаар тушаалаар “Ушгийн хорт хавдар”, 2024 оны А/353 дугаар тушаалаар “Хөхний хорт хавдар”, А/354 дугаар тушаалаар “Элэгний хорт хавдар”, А/355 дугаар тушаалаар “Умайн хүзүүний хорт хавдар”-ын дэд ажлын хэсгүүд тус тус байгуулагдсан.

Зонхилох байрлалын буюу элэг, ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэс, ушги, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг, оношилгоог үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд баг тус бүр 1 удаа, дэд ажлын хэсгүүд хамтран 8 удаа, нийт 14 удаа танхимаар хуралдаж, эрт илрүүлэг зохион байгуулах алгоритм, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөц, эдийн засгийн судалгааг гаргаж, 2025 оноос Улаанбаатар хотод зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Одоогоор эрт илрүүлгийн зааврын төслийг боловсруулсан ба дурс оношилгоо, дуран, хавдрын эрт илрүүлгийн сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.	Арга хэмжээ 2.1. Боловсролын зэргээ ахиулан судалгааны ажил хийнэ.	Суралцсан кредит цаг	3 кредит цаг	5 кредит цаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистрын 32 кредит цагийн сургалтад хамрагдсан.	1-12cap	100%
2.	Арга хэмжээ 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт (A3)-д хамрагдах.	Түвшин ахисан серфитикат авсан эсэх /Тийм:1, Үгүй:0/	-	1	ЭМЯ-ны ТЗҮГ-с Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт (A3)-д хамрагдсан.	1-12 cap	100%

ТАЙЛАН ХЯНАСАН:

.....

(Албан тушаал)

..... / /

(Нэр, гарын үсэг)

2024.12.05

(Огноо)

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах шинийгээч

(Албан тушаал)

Б.Нямж 1. Б.Нямж

(Нэр, гарын үсэг)

2024.12.05

(Огноо)

